

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2012 оны 8-р сарын 29-ний байдлаар*


2012 оны 8-р сарын 29-ний байдлаар гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.6 хувиар буурсан бол, өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад 0.4 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад үхрийн махны үнэ 3.1-4.1 хувь, адууны махны үнэ 3.9 хувь, хонины махны үнэ 1.3 хувиар буурсан бол, ямааны махны үнэ 0.1 хувиар өссөн байна.

Махны үнийг өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад үхрийн цул махны үнэ 0.5 хувь, хонины махны үнэ 4.1 хувиар өссөн бол, ямааны болон адууны махны үнэ тогтвортой байв.

2012 оны 8-р сарын 29-ний байдлаар 1 кг хонины /ястай/ махны үнэ дунджаар 7363 төгрөг, хонины цул мах 7540 төгрөг, үхрийн /ястай/ мах 7771 төгрөг, үхрийн цул мах 8829 төгрөг, ямааны мах 5820 төгрөг, адууны мах 6083 төгрөгийн үнэтэй байлаа (Зураг 1; 2).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ **Зураг 2.** Цул махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар гурилын үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад “Алтан тариа” ХК-ны задгай 1-р зэргийн гурил 0.3 хувиар өссөн бол, савласан дээд гурилын үнэ тогтвортой байв. Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад гурилын үнэ тогтвортой байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар элсэн чихрийн үнийг өмнөх сарын үнэтэй харьцуулахад 2.4 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Цагаан будааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 2.7 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 0.2 хувиар өссөн байна (Зураг 3).

Зураг 3



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 14.0 хувь, сонгины үнэ 6.7 хувиар өссөн бол, байцааны үнэ 40.1 хувь, луувангийн үнэ 30.5 хувиар буурчээ.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад байцааны үнэ 5.8 хувь, луувангийн үнэ 29.1 хувь, төмсний үнэ 2.4 хувиар буурсан бол, сонгины үнэ 1.9 хувиар өссөн байна.

Сүү, өндөг, ургамлын тос, цэцгийн тосны дундаж үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад задгай сүүний үнэ 8.4 хувиар өссөн бол, 1 литрийн савлагаатай сүүний үнэ 1.0 хувь, 0.5 литрийн савлагаатай сүүний үнэ 7.0 хувиар буурчээ.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад 0.5 литрийн савлагаатай сүүний үнэ 1.0 хувиар буурчээ.

Ургамлын тосны үнийг өмнөх сарын үнэтэй харьцуулахад 0.4 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Цэцгийн тосны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 3.4 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, хонь, ямаа, үхрийн мах, цагаан будаа, шингэн сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 600-950 төгрөгийн хооронд худалдаалагдсан байна. Гурилын үнийг өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Баян-Өлгий аймагт 10 төгрөгөөр өссөн бол, Дорноговь аймагт 70 төгрөгөөр буурчээ.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 600 төгрөг байхад, Хөвсгөл аймагт 950 төгрөг байгаа нь өндөр үнэ байлаа.

Махны үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар хонины махны дундаж үнэ өмнөх 7 хоногийнхоос Увс, Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Дорноговь, Төв, Дорнод, Сүхбаатар аймагт 100-500 төгрөгөөр буурсан бол, Архангай аймагт 200 төгрөгөөр өсчээ. Хонины махны үнэ 5200-7000 төгрөгийн хооронд худалдаалагдсан байна. Хонины махны үнэ Баян-Өлгий, Өмнөговь, Ховд аймагт 7000 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байгаа бол, Баянхонгор аймагт 5200 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Увс, Архангай, Дорноговь, Дорнод аймагт 100-500 төгрөгөөр буурсан бол, Баянхонгор аймагт 200 төгрөгөөр өссөн байна. Үхрийн махны үнэ Говь-Алтай, Өвөрхангай аймагт 8000 төгрөг буюу хамгийн өндөр үнэтэй байхад, Баянхонгор аймагт 6000 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байлаа.

Ямааны махны үнэ Баянхонгор, Өвөрхангай, Дорноговь, Төв, Дорнод, Сүхбаатар аймагт 100-1000 төгрөгөөр буурсан бол, бусад аймагт тогтвортой байна. Ямааны махны үнэ Баянхонгор аймагт хамгийн хямд буюу 4300 төгрөг байхад, Өмнөговь, Ховд аймагт 6500 төгрөг буюу хамгийн өндөр үнэ байлаа.

Малын сүүний үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар малын сүү аймгуудад 500-1725 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Сүүний үнэ Баян-Өлгий, Дорноговь, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар аймагт 50-200 төгрөгөөр өссөн бол, Хэнтий, Орхон аймагт 100-200 төгрөгөөр буурч, бусад аймагт тогтвортой байв.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2012 оны 8-р сарын 29-ний байдлаар цагаан будааны үнийг өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Дундговь, Увс аймагт 20-100 төгрөгөөр буурсан байна. Аймгуудад цагаан будаа 1 кг нь 1400-2000 төгрөгөөр худалдаалагдсан байна.

Элсэн чихрийн үнийг өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад Дундговь, Увс аймагт 30-100 төгрөгөөр буурсан бол, бусад аймагт тогтвортой байлаа. Аймгуудад элсэн чихэр 1 кг нь 1500-1800 төгрөгийн хооронд худалдаалагдсан байна.